



ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Үндсэн хуулийн эрх зүйн маргаан)¹

ЦЭЦЭРЛЭГИЙН СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧИЙГ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ЭЗЭМШЭЭГҮЙ ГЭХ ШАЛТГААНААР АЖЛААС НЬ ХАЛАХАД ҮНДЭСЛЭЛ БОЛСОН ХОЛБООНЫ ХУУЛИЙН ХОЛБОГДОХ ЗОХИЦУУЛАЛТ НЬ ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ЗӨРЧСӨН

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 41

Шүүхийн шийдвэрийн огноо: 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр

Шийдвэрийн төлөв: Маргаан бүхий заалтыг Оросын Холбооны Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэж шийдвэрлэсэн.

МАРГААНЫ ТУХАЙ ТОВЧ

1990 оноос эхлэн цэцэрлэгийн сурган хүмүүжүүлэгчээр ажилласан иргэн И.В.С.-г 2017 оны 08 дугаар сард цэцэрлэгийн удирдлага 2012 оны 12-р сарын 29-ний өдрийн 273 дугаартай “Оросын Холбооны Улсын Боловсролын тухай” Холбооны хуулийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн ажлаас нь чөлөөлжээ.

Иргэн И.В.С. нь “Оросын Холбооны Улсын Боловсролын тухай” Холбооны хуулийн² 46 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “мэргэжлийн лавлах болон (эсвэл) мэргэжлийн стандартад заасан шаардлагыг хангасан дунд мэргэжлийн эсвэл дээд мэргэжлийн боловсролтой этгээдүүдэд багшлах эрх олгоно”. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасан “боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын багш нарын албан тушаал, боловсролын байгууллагын даргын албан тушаалын нэр томъёог Оросын Холбооны Улсын Засгийн газар батална” гэх зохицуулалтууд Оросын Холбооны Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянуулахаар Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхэд өргөдөл гаргасан байна.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. “Оросын Холбооны Улсын Боловсролын тухай” Холбооны хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан дээрх зохицуулалт багшаар ажиллах эрх олгоход тавигдах шаардлагыг тогтоогоогүй ба өргөдөл гаргагчийн Оросын Холбооны Улсын Үндсэн хуульд заасан эрхийг нь хөндөөгүй байна. Тиймээс “Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай” Холбооны Үндсэн хуулийн³ 43

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: https://www.consultant.ru/document/cons_doc_LAW_311103/92d969e26a4326c5d02fa79b8f9cf4994ee5633b/

² Федеральный закон от 29.12.2012 N 273-ФЗ "Об образовании в Российской Федерации" // Собрание законодательства Российской Федерации. – 2012. – № 53 (ч. 1). – Ст. 7598. // (2012 оны 12-р сарын 29-ний өдрийн N 273 “Оросын Холбооны Улсын Боловсролын тухай” Холбооны хууль // Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн цуглуулга. – 2012. – № 53 (1 х.) – Ст. 7598.)

³ Федеральный конституционный закон «О Конституционном Суде Российской Федерации» от 21 июля 1994 года № 1-ФКЗ // Собрание законодательства. 1994 г., № 13. // (1994 оны 07 дугаар сарын



- дугаар зүйлийн 2 дахь хэсэг⁴ болон 68 дугаар зүйлд⁵ заасны дагуу "Оросын Холбооны Улсын Боловсролын тухай" Холбооны хуулийн 46 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг Оросын Холбооны Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгосон болно.
2. Боловсролын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын багш нарт тавигдах заавал дунд мэргэжлийн эсвэл дээд мэргэжлийн боловсролтой байна гэсэн шаардлага "Оросын Холбооны Улсын Боловсролын тухай" Холбооны хуульд тусгагдсан байх бөгөөд тус Холбооны хууль нь 2013 оны 09-р сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн байна. Тус хууль хүчин төгөлдөр болсон хэдий ч иргэн И.В.С. 2017 оны 08 дугаар сар хүртэл 22 дугаар цэцэрлэгт сурган хүмүүжүүлэгчээр хэвээр ажиллажээ.
 3. Оросын Холбооны Улсын Боловсрол, шинжлэх ухааны яамны 2014 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн 276 дугаартай тушаалаар батлагдсан "Боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын багш нарыг аттестатчилах журмын" 23 дахь заалтад заасны дагуу дунд мэргэжлийн эсвэл дээд мэргэжлийн боловсрол эзэмшээгүй этгээдүүдийг холбогдох багшийн албан тушаалд аттестатчиллын комиссын санал болгосноор томилж болдог. Волгоград мужийн Боловсрол, шинжлэх ухааны яамны 2012 оны 12-р сарын 26-ны өдрийн тушаалаар аттестатчиллын үр дүнг үндэслэн И.В.С.-д таван жилийн хугацаагаар 1-р мэргэшлийн зэрэг олгосон байна.
 4. Хэдийгээр "Оросын Холбооны Улсын Боловсролын тухай" Холбооны хуулийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь тус хууль хүчин төгөлдөр болсны дараа буюу 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш зохих түвшний мэргэжлийн чиглэлээр бэлтгэгдээгүй этгээдүүдийг боловсролын байгууллагын сурган хүмүүжүүлэгчийн албан тушаалд томилохгүй байхаар заасан хэм хэмжээ боловч тус зохицуулалт 2013 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сурган хүмүүжүүлэгчээр ажлаа амжилттай хийж байсан, хөдөлмөрийн харилцаанд аль хэдийн орсон албан хаагчдыг шаардлагатай мэргэжлийн боловсрол эзэмшээгүй гэсэн шалтгаанаар ажлаас нь халах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
 5. Дээрх үндэслэлээр Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхээс "Боловсролын тухай Холбооны хууль хүчин төгөлдөр болохоос өмнө ажилд орсон, амжилттай ажиллаж байсан, эрхэлж буй албан тушаалдаа тохирч байгааг нь аттестатчиллын комиссоос хүлээн зөвшөөрсөн, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сурган хүмүүжүүлэгчдийн хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох үндэслэл болгон ашиглаж байгаа Оросын Холбооны Улсын Боловсролын тухай Холбооны хуулийн 46 дугаар зүйлийн 1 дэх хэсэг нь Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг⁶, 2 дугаар зүйл⁷,

21-ний өдрийн № 1 "Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай" Холбооны Үндсэн хууль // Оросын Холбооны Улсын хууль тогтоомжийн цуглуулга. 1994 он., №13.)

⁴ "Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай" Холбооны Үндсэн хуулийн 43 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүх энэ Холбооны Үндсэн хуульд заасан шаардлагуудын дагуу өргөдлийг хүлээн авах боломжгүй тохиолдолд өргөдлийг хүлээн авахаас татгалзах тухай шийдвэр гаргана.

⁵ "Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн шүүхийн тухай" Холбооны Үндсэн хуулийн 68 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох.

⁶ Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Оросын Холбооны Улс – Орос бүгд найрамдах засаглалын хэлбэртэй, ардчилсан, холбооны, бүрэн эрхт улс.

⁷ Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн 2 дугаар зүйлд зааснаар хүн, түүний эрх, эрх чөлөө нь хамгийн дээд үнэт зүйл юм. Хүн болон иргэний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрөх, сахих, хамгаалах нь төрийн үүрэг.



7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг⁸, 17 дугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсэг⁹, 18 дугаар зүйл¹⁰, 19 дүгээр зүйлийн 1 болон 2 дахь хэсэг¹¹, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг¹² болон 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэг¹³ нийцээгүй” хэмээн шийдвэрлэжээ.

---o0o---

⁸ Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Оросын Холбооны Улс - бодлого нь хүний зохистой амьдрал, чөлөөт хөгжлийг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн иргэдийн нийгмийн баталгааг хангадаг улс.

⁹ Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Оросын Холбооны Улсад хүний эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрнө Мөн зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүний үндсэн эрх, эрх чөлөө нь салгаж болшгүй бөгөөд хүн бүрт төрөхөөс нь заяагдана.

¹⁰ Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу хүний болон иргэний эрх, эрх чөлөө нь хүчин төгөлдөр шууд хэрэгжинэ.

¹¹ Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хууль шүүхийн өмнө бүгд тэгш эрхтэй. Мөн зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар иргэдийн эрхийг арьс өнгө, үндэс, угсаа, хэл, шашин шүтлэг аливаа хэлбэрээр хязгаарлахыг хориглоно.

¹² Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хувь хүний нэр төрийг төр хамгаална...

¹³ Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу эрх чөлөөтэй хөдөлмөрлөнө (орос хэлээр. труд свободен).